



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/47

Хэрлэн сум

“Өсвөр үеийн шигшээ баг”-ийн спортын нэр
төрлийг тогтоож, зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2017 оны “Журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Өсвөр үеийн шигшээ баг”-ийн тамирчдын 2022 оны төсвийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, дасгалжуулагчийн урамшууллын төсвийг хоёрдугаар хавсралтаар, спортын нэр төрөл, тоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 130,000,000 (нэг зуун гучин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

3. Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган, хичээл сургуулилт, ажлын үр дүнг улирал бүр тооцон хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Г.Нэргүйбаатар)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231018187

Аймгийн Засаг даргын 2022 оны
 01 дүгээр сарын 25 өдрийн А/47
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Хэнтий аймгийн Өсвөр үеийн шигшээ багийн 2022 оны төсвийн хуваарь

| № | Жилийн төсөв | Жилийн төсөв | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар |
|---|---------------------------------------|--------------|------------|------------|------------|-----------|-----------|------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| 1 | Урамшуулал | 77,760,000 | 16,320,000 | 18,320,000 | 6,520,000 | 2,520,000 | 5,040,000 | 9,900,000 | 3,900,000 | 4,200,000 | 2,520,000 | 3,900,000 | 2,100,000 | 2,520,000 |
| 2 | Томилолт | 2,915,000 | 530,000 | 530,000 | 530,000 | 530,000 | | | | | | 265,000 | 530,000 | |
| 3 | Уралдаан, тэмцээний зардал | 14,500,000 | 3,500,000 | 3,500,000 | 3,500,000 | 2,000,000 | | | | | | 1,000,000 | 1,000,000 | |
| 4 | Нэг удаагийн шагнал, урамшуулал | 4,825,000 | | | | | | 2,412,500 | | | | | | 2,412,500 |
| 5 | Бусад зардал | 30,000,000 | | 30,000,000 | | | | | | | | | | |
| 6 | Дүн | 130,000,000 | 20,350,000 | 52,350,000 | 10,550,000 | 5,050,000 | 5,040,000 | 12,312,500 | 3,900,000 | 4,200,000 | 2,520,000 | 5,165,000 | 3,630,000 | 4,932,500 |

Аймгийн Засаг даргын 2022 оны
 ... дүгээр сарын ... өдрийн
 дугаар захирамжийн хоёр дугаар хавсралт



Хэнтий аймгийн өсвөр үеийн шигшээ багийн 2022 оны урамшууллын сан

| Дасгалжуулагчийн нэрс | Спортын төрөл | Жилийн урамшууллын сан | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар |
|-------------------------------------|-----------------|------------------------|-------------------|-------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|
| Ц.Галхүү | Бадминтон | 4,200,000 | | 2,100,000 | | | | | | 2,100,000 | | | | |
| Т.Баяржргал | Буудлага | 5,040,000 | | | | 2,520,000 | | | | | | | | 2,520,000 |
| Д.Жаргалсайхан | Волейбол | 9,600,000 | 4,800,000 | 4,800,000 | | | | | | | | | | |
| Г.Эрдэнэбилэг | Жүдо бөх | 4,200,000 | 1,100,000 | 1,000,000 | | | | | | | | | 2,100,000 | |
| О.Шинэхүү | Сагсан бөмбөг | 4,200,000 | 1,100,000 | 1,000,000 | | | | | | 2,100,000 | | | | |
| Н.Ганзориг | Самбо бөх | 5,040,000 | 1,520,000 | 1,000,000 | 2,520,000 | | | | | | | | | |
| Б.Цогтгэрэл | Чөлөөт бөх | 7,800,000 | 1,900,000 | | 2,000,000 | | | 3,900,000 | | | | | | |
| Ш.Бямбадорж | Үндэсний бөх | 7,800,000 | | | | | | 3,900,000 | | | | 3,900,000 | | |
| Б.Энхбаяр | Шатар | 7,800,000 | 1,900,000 | 3,900,000 | 2,000,000 | | | | | | | | | |
| Б.Төрбат | Хөнгөн атлетик | 4,200,000 | 2,100,000 | | | | | 2,100,000 | | | | | | |
| | Даам | 5,040,000 | | | | | 2,520,000 | | | | 2,520,000 | | | |
| Н.Эрдэнэбаяр | Ширээний теннис | 5,040,000 | | 2,520,000 | | | 2,520,000 | | | | | | | |
| Б.Үүлэнтайсуухүү | Хүндийн өргөлт | 7,800,000 | 1,900,000 | 2,000,000 | | | | | 3,900,000 | | | | | |
| Урамшууллын сангийн нийт дүн | | 77,760,000 | 16,320,000 | 18,320,000 | 6,520,000 | 2,520,000 | 5,040,000 | 9,900,000 | 3,900,000 | 4,200,000 | 2,520,000 | 3,900,000 | 2,100,000 | 2,520,000 |

Аймгийн Засаг даргын 2022 оны
...01... дүгээр сарын...25...өдрийн...
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



"Өсвөр үеийн шигшээ баг"-ийн спортын нэр төрөл, тоо

1. Бадминтон
2. Буудлага
3. Волейбол
4. Даам
5. Жүдо бөх
6. Сагсан бөмбөг
7. Самбо бөх
8. Чөлөөт бөх
9. Үндэсний бөх
10. Шатар
11. Ширээний теннис
12. Хөнгөн
атлетик
13. Хүндийн
өргөлт